

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, ЦУГЛУУЛАХ,
АНГИЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ,
УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Тээврийн хэрэгслийн ашиглалтаас бий болсон хог хаягдлыг цуглуулж ангилан ялгах, тээвэрлэх, орчин үеийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл технологийн түвшинд дахин боловсруулж сэргээн ашиглах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байдлаар устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага болон тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүссэн хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Хог хаягдлын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, Агаарын тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, Усны тухай хууль, Эрүүл ахуйн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн акт тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журам, стандарт болон энэхүү журмыг дагаж мөрдөнө.

**ХОЁР. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ,
ЦУГЛУУЛАХ, АНГИЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ, БАЙГУУЛЛАГА**

2.1. Тээврийн хэрэгслийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг Хог хаягдлын тухай хуулийн 8.1.4-т заасан зөвшөөрөл бүхий, 8.1.9.а-д заасны дагуу бүртгүүлсэн, бүртгэлийн дугаар бүхий иргэн, аж ахуй нэгж, байгууллага гүйцэтгэнэ.

2.2. Тээврийн хэрэгслийн хог хаягдал дахин ашиглах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгч нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р зүйлийн дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэнэ.

2.3. Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хог хаягдлын дагалдах бичигт заасан хог хаягдал мөн эсэх, үл зохицол байгаа эсэхийг шалган гарын үсэг зурж, хүлээн авна.

2.4. Тээврийн хэрэгслийн хог хаягдал үүсгэгч болон эрх бүхий этгээд Хог хаягдлын тухай хуулийн 8.1.3-д заасан журмын дагуу хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

2.5. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хог хаягдлын үл зохицол илэрсэн тохиолдолд уг хог хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж болно. Энэ тохиолдолд холбогдох зардлыг буруутай этгээд хариуцна.

2.6. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал үүсгэгч нь үүссэн болон хуримтлагдсан хог хаягдлын хэмжээний талаар бүртгэл хөтлөх бөгөөд бүртгэлийг хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлснээр дуусгавар болгож, дахин эхлэх үед бүртгэлийг шинээр хөтөлж эхэлнэ.

2.7. Үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлэхдээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтын дагуу аюултай хог хаягдлын дагалдах бичгийг бүрдүүлж, бүртгэл хөтөлнө.

2.8. Үүсгэгч болон өмчлөгч нь тээврийн хэрэгслийн хог хаягдалд дагалдах бичгийг 4 хувь үйлдэх бөгөөд өөрөө болон тээвэрлэгч гарын үсэг зурж баталгаажуулсны дараа 1 хувийг өөрт үлдээж, бусад 3 хувийг тээвэрлэгчид хог хаягдлын хамт хүлээлгэн өгнө.

2.9. Тээвэрлэгч нь 3 хувь хог хаягдлын дагалдах бичгийг хог хаягдлын хамт хүлээн авагчид хүргэж, гарын үсэг зуруулж баталгаажуулан, 1 хувийг хог хаягдал хүлээн авагчид өгч, 1 хувийг тээвэрлэгч өөртөө үлдээнэ. 3 дахь хувийг үүсгэгчид эргүүлэн өгнө.

2.10. Үүсгэгч нь өөрт үлдээсэн хог хаягдлын дагалдах бичгийг хүлээн авагч гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичгийн хувийг хүлээн авах хүртэлх хугацаанд хадгална.

2.11. Үүсгэгч нь гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичиг, үүсгэсэн болон тээвэрлүүлсэн хог хаягдлын бүртгэл, тайлангийн баримт материалыг 5 жил хадгална.

2.12. Автомашиныг задлах, дахин боловсруулах үйл ажиллагаанд ашиглалтаас хасагдах автомашиныг хүлээн авсан бүртгэлийн ажилтан нь дараах мэдээллийг бүртгэж, гэрэл зургийг нь авна. Үүнд:

2.12.1. Олгосон он сар өдөр

2.12.2. Бүртгэлийн дугаар

2.12.3. Тээврийн хэрэгслийн төрөл

2.12.4. Тээврийн хэрэгслийн марк, загвар

2.12.5. Ашиглалтаас хасагдах үеийн спидометрийн заалт

2.12.6. Тээврийн хэрэгслийн эзэмшигчийн овог нэр, хаяг

2.12.7. Ашиглалтаас хасагдах үеийн хүсэлт гаргагчийн овог нэр, хаяг

2.13. Ашиглалтаас хасагдсан автомашиныг задлах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх бүртгэлтэй аж ахуйн нэгж нь хүсэлт гаргагч буюу тээврийн хэрэгсэл эзэмшигчдэд дахин боловсруулах үйлдвэрт тушаасан талаар тухайн үйлдвэрийн тодорхойлолтыг гаргаж өгнө.

ГУРАВ. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ

3.1. Хог хаягдлыг цуглуулах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.8-д заасныг ойлгох ба мөн хуулийн 24 дүгээр зүйл хамаарна.

3.2. Хог хаягдлын төрөл, ангиллын мэдээллийг ил харагдахуйц байршуулсан байна.

3.3. Байгаль орчинд сөргөөр үл нөлөөлөх нөхцлөөр буюу чанарын шаардлага хангасан байна.

3.4. Хуучирсан, ашиглалтаас гарсан тээврийн хэрэгслийг цуглуулахдаа дараах аргыг сонгож болно.

3.4.1. Шинийг худалдахдаа хуучныг нь эргүүлэн авч, үнийн хөнгөлөлт үзүүлэх;

3.4.2. Хуучирсан, ашиглалтаас гарсан тээврийн хэрэгсэл, эд ангийг тодорхой үнээр худалдан авах, эсхүл шинэ бүтээгдэхүүн худалдан авахад хөнгөлөлт үзүүлэх, урамшуулал олгох;

3.5. Үүсгэгч болон өмчлөгч нь тээврийн хэрэгслийн шингэний тухай бүртгэл хөтлөх бөгөөд үүссэн хаягдлыг устгах, дахин боловсруулах зөвшөөрөл бүхий байгууллагад шилжүүлнэ.

3.6. Тээврийн хэрэгслийн хог хаягдал үүсгэгч нь аюултай хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 23.1-д заасан хугацаанд эх үүсвэр дээр түр хадгална.

3.7. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал үүсгэгч болон өмчлөгч нь аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалахад Хог хаягдлын тухай хуулийн 23.3-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна.

3.7.1. Хог хаягдлыг ангилан ялгасан байх;

3.7.2. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлыг агуулах сав нь агуулж буй хог хаягдалтайгаа урвалд ордоггүй материалаар хийгдсэн, эсхүл ийм материалаар доторлосон байх;

3.7.3. Хог хаягдлын аюулын шинж чанар болон аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг итгэмжлэгдсэн лабораториор тодорхойлуулсан байх;

3.7.4. Үүсэх хог хаягдлын төрөл, кодыг хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу тогтоосон байх;

3.8. Хог хаягдал цуглуулах иргэн, аж ахуй нэгж, байгууллагын ажилтан нь дараах ерөнхий шаардлагыг хангасан байна.

3.8.1. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зохих мэдлэгтэй байх;

3.8.2. Хөдөлмөр хамгааллын нэг бүрийн хэрэгсэл хэрэглэх;

3.8.3. Хог хаягдал цуглуулах үйл ажиллагааны бүрэн мэдлэгтэй, хог хаягдал үүсгэгчийн онцлогийг тодорхойлох чадвартай байх.

ДӨРӨВ. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН АНГИЛАЛ

4.1. Хог хаягдлыг ангилах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.7-д заасныг ойлгоно.

4.2 Автотээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлын жагсаалт

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг	Дэд бүлгийн код	Хог хаягдлын дэд бүлэг	Хог хаягдлын төрлийн код	Хог хаягдлын төрөл	Аюулын зэрэглэл
13	Хаягдал тос ба шингэн түлш (хүнсний тос, Д ба Л бүлгийн тос хамаарахгүй)	13.02	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тосны хаягдал	13 02 01*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны хлор агуулсан эрдсийн тос	A
				13 02 02*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны хлор агуулаагүй эрдсийн тос	A
				13 02 03*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны нийлэг тос	A
				13 02 04*	Биоадралд түргэн ордог хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны тос	A
				13 02 05*	Хөдөлгүүр, хурдны хайрцагны болон тосолгооны бусад тос	A
		13 05	Шингэн түлшний хаягдал	13 0 501*	Түлшний тос, дизель	A
				13 0 502*	Бензин	A
				13 0 503*	Бусад түлш (холимог түлш орно)	A
				16 01 02*	Ашиглалтаас гарсан автомашин	X
				16 01 04*	Тосны шүүр	A
				16 01 05*	Мөнгөн ус агуулсан эд анги	X
				16 01 06*	Полихлорт бифенил (PCBs) агуулсан эд анги	X
				16 01 07*	Тэсрэмтгий эд анги (хамгаалалтын дэрг.м)	A
				16 01 08*	Асбест бүхий тоормосны жийргэвч (накладка)	A
				16 01 10*	Тоормосны шингэн	A
				16 01 11*	Аюултай нэгдэл агуулсан антифризийн шингэн	X

				16 01 18*	16 01 04 -16 01 08 болон 16 01 10, 16 01 11-д заагдсанаас бусад аюултай эд анги	X
		16 02	Цахилгаан болон цахим тоног төхөөрөмжийн хаягдал	16 02 01*	Полихлорт бифенил (PCBs) агуулсан трансформатор, конденсатор	X
				16 02 02*	16 02 01-д дурьдснаас бусад Полихлорт бифенил (PCBs) агуулсан буюу бохирдсон хаягдал тоног төхөөрөмж	X
				16 02 03*	Хлор фторт нүүрстөрөгчид, HCFC, HFC агуулсан хаягдал тоног төхөөрөмж	X
				16 02 04*	Чөлөөт асбест агуулсан хаягдал тоног төхөөрөмж	X
				16 02 05*	16 01 01 - 16 01 04 -д зааснаас бусад хортой бодис агуулсан хаягдал тоног төхөөрөмж (16 06-д заасан батерей, аккумулятор болон мөнгөн ус агуулсан унтраагуур, катодын лампны шил гэх мэт аюултай гэж тэмдэглэсэн эд анги)	X
				16 02 07*	Хаягдал тоног төхөөрөмжөөс ялгаж авсан хортой бодис	A
				16 06	Батерей, аккумулятор	16 06 01*
		16 06 02*	Никель - Кадмийн батерей			A
		16 06 03*	Мөнгөн ус агуулсан батерей			A
		16 06 06*	Батерей, аккумулятороос ялгаж авсан электролитийн уусмал			A
		19 13	Бохирдсон хөрс, газрын доорх усны цэвэрлэгээнээс үүсэх	20 01 21*	16 06 01, 16 06 02, 16 06 03-д заасан батерей, аккумулятор болон ангилж ялгаагүй эдгээр батерей, аккумуляторын холимог	A

			хаягдал			
--	--	--	---------	--	--	--

4.3. Дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч эрх бүхий этгээдийн хэрэгцээ шаардлага, тухайн орон нутгийн онцлог, шаардлагад тулгуурласан төрлөөр хог хаягдлыг ангилан ялгаж болно.

4.4. Тээврийн хэрэгслийн ангилан ялгах хог хаягдлыг аюулын зэрэглэлээс хамаарч хогийн сав, хашааг өнгөөр ялгасан, эсвэл ангилах ялгах зориулалтын тэмдэг, тэмдэглэгээ бүхий байж болно.

ТАВ. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ТЭЭВЭРЛЭХ

5.1.Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг тээвэрлэхэд Хог хаягдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийг баримтална.

5.2. Эрх бүхий этгээд нь ангилсан хог хаягдал тус бүрийг зориулалтын газар хүргэх ажлыг зохион байгуулна.

5.3. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

5.4. Тээвэрлэгч нь үүсгэгч болон өмчлөгчтэй байгуулсан гэрээний үндсэн дээр зориулалтын саванд савласан, “Аюултай хог хаягдал” гэсэн тэмдэг, тэмдэглэгээтэй, хог хаягдлын дагалдах бичиг бүхий аюултай хог хаягдлыг үүсгэгчээс хүлээн авч тээвэрлэнэ.

5.5. Тээвэрлэгч нь үүсгэгчийн огноо, гарын үсэг бүхий хог хаягдлын 3 хувь үйлдсэн дагалдах бичгийг бүрэн, үнэн зөв бөглөгдсөн эсэхийг шалгаж, гарын үсэг зурж хүлээн авна.

5.6. Тээвэрлэгч нь үүсгэгчээс хүлээн авсан аюултай хог хаягдлын бүрэн бүтэн байдал, аюулгүй байдлыг ханган тээвэрлэж, дагалдах бичигт заасан аж ахуйн нэгжид хүлээлгэж өгнө.

5.7. Тээвэрлэлт дууссаны дараа хүлээн авагчийн гарын үсэг зурж баталгаажуулсан хог хаягдлын дагалдах бичгийн 1 хувийг үүсгэгчид буцаан өгч, 1 хувийг өөртөө авна.

5.8. Үүсгэгч болон өмчлөгчийн буруутай үйл ажиллагааны улмаас тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлын дагалдах бичиг, төрөл, тоо хэмжээтэй таарахгүй байгаа тохиолдолд хүлээн авагч уг хаягдлыг хэсэгчлэн болон бүхэлд нь хүлээн авахаас татгалзаж хог хаягдлын дагалдах бичгийг шинээр бүрдүүлнэ.

5.9. Хүлээн авагч хог хаягдлыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд энэ тухай бичгээр гаргасан тайлбарыг хог хаягдал болон түүний дагалдах бичгийн хамт үүсгэгчид хүлээлгэн өгнө.

5.10. Хэрэв тээвэрлэлтийг нэгээс дээш тээвэрлэгч (жишээ нь: авто болон төмөр замын холимог тээвэр) гүйцэтгэж байгаа тохиолдолд тээвэрлэгч бүр гарын үсэг зурж баталгаажуулсан дагалдах бичгийг хог хаягдлын хамт дараагийн тээвэрлэгчид хүлээлгэн өгнө. Эцсийн тээвэрлэгчээс бусад нь зөвхөн хог хаягдлын дагалдах бичгийн хуулбарыг өөртөө үлдээнэ. Эцсийн тээвэрлэгч дагалдах бичгийн эх хувийг гарын үсэг зурж баталгаажуулан үүсгэгчид хүлээлгэн өгнө.

5.11.Тээвэрлэгч нь өөрт үлдсэн хог хаягдлын дагалдах бичгийг 10 жил хадгална.

5.12. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал тээвэрлэх автотээврийн хэрэгсэл нь “Аюултай хог хаягдал” гэсэн бичиглэл, холбогдох стандартад заасан анхааруулах тэмдэг байрлуулсан, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэх ба аюултай хог хаягдлыг ачих, буулгах, тээвэрлэхэд ЗГ-ын 2018 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-д заасан тавигдах нөхцөл шаардлагыг мөрдөнө.Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлыг тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавигдах ерөнхий шаардлагын стандартыг хангасан, стандартаар тогтоосон тэмдэг, тэмдэглэгээтэй, зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

5.13. Аюултай хог хаягдал тээвэрлэх тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхтэй, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна.

5.14. Тээвэрлэгч нь тээврийн хэрэгслийг аюултай хог хаягдал асгарах, алдагдах үед ашиглах багаж хэрэгсэл, материалаар хангах бөгөөд тээврийн хэрэгслийн жолооч нь тэдгээрийг ашиглах сургалтад хамрагдаж, зохих дадал эзэмшсэн байна.

5.15. Тээвэрлэлтийн үед аюултай хог хаягдал асгарах, алдагдах тохиолдолд тээвэрлэгч нь дараах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авна.

5.16. Тээвэрлэгч нь асгарсан, алдагдсан хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй түвшинд хүртэл цэвэрлэх арга хэмжээг авах бөгөөд уг арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг буруутай этгээд хариуцна.

5.17. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал тээвэрлэх жолооч нь тухайн ангилалд тохирох жолоодох эрхийн үнэмлэхтэй, аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдсан байна.

5.18. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал тээвэрлэгч нь нийцгүй аюултай хог хаягдлыг хамт тээвэрлэхийг хориглоно.

5.19. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал тээвэрлэгч нь тухайн жил тээвэрлэсэн аюултай хог хаягдлын талаарх мэдээллийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан аюултай хог хаягдал тээвэрлэх үйл ажиллагааны тайлангийн маягтын дагуу гаргаж, “Хог хаягдлын

улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”-д заасан байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

ЗУРГАА. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ

6.1. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах байгууламж нь Хог хаягдлын тухай хуулийн 25.3-т заасан шаардлагыг хангасан байна.

6.2. Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч эрх бүхий этгээд түүхий эд болох хог хаягдлыг өөрөө болон хог хаягдал цуглуулах эрх бүхий этгээдээр дамжуулан цуглуулж болно.

6.3. Эрх бүхий этгээд өөрийн үйлдвэрийн байранд, байгаль орчинд ээлтэй нөхцөлөөр, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, технологиор хог хаягдлыг нэрэх, цэвэрлэх, сэргээх аргаар боловсруулж, эргүүлэн ашиглах, эдийн засгийн хувьд ашигтай хог хаягдлыг анхны хэлбэрт оруулах үйл ажиллагаа эрхэлж болно.

6.4. Задлах, дахин боловсруулах ААН нь тээврийн хэрэгслийг хогийг дахин боловсруулаад үлдсэн эд ангийг бутлан дахин боловсруулах ААН-д шилжүүлэх ёстой. Ийм тохиолдолд машины хог хаягдалтай өөр хог хаягдлыг холихгүй байхад анхаарах ёстой.

6.3. Эрх бүхий этгээд өөрийн үйлдвэрийн байранд тээврийн хэрэгслийн хог хаягдлыг дахин боловсруулахдаа орон нутгийн мэргэжлийн хяналт, цагдаа болон онцгой байдлын байгууллагад өөрийн байгууламжийн бүтэц, үйл ажиллагаа, устгаж, боловсруулж байгаа хог хаягдлын шинж чанар, гарч болзошгүй аюул осол, ажилтнуудын ажлын байрны байршил, байгууламжийн доторх орц, гарц, зам, ослын гарцын талаар жил бүр танилцуулж, мэдээллээр хангана.

6.4. “Аюултай! Гадны хүн зөвшөөрөлгүй орохыг хориглоно” гэсэн анхааруулгыг гол хаалга болон дотоод байгууламжийн хаалга тус бүр дээр хамгийн багадаа 10 м-ийн зайнаас харагдахуйцаар байрлуулах.

ДОЛОО. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ БУЛШИЛЖ УСТГАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

7.1. Энгийн хог хаягдлыг булшлах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.14-д заасныг ойлгох ба мөн хуулийн 34 дүгээр зүйл хамаарна.

7.2. Тээврийн хэрэгслийн байгальд 5-10 жилд хоргүйгээр уусч алга болох энгийн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт зөвшөөрөгдсөн ландфилл талбайд зориулалтын тоног төхөөрөмжөөр булшилна.

7.3. Байгальд 10-аас дээш жилийн дараа уусах, байгальд хортой нөхцөл үүсгэх хог хаягдлыг булшлахаас бусад аргаар устгана.

7.4. Хог хаягдлыг булшлах ажиллагаа нь дэлхийн эрүүл мэндийн болон байгаль орчны холбогдох байгууллагуудаас гаргасан зөвлөмжийн дагуу байгаль орчинд хоргүй нөхцөлөөр, ландфилл аргаар хийгдэнэ.

7.5. Тээврийн хэрэгслийн хог хаягдал булшлах төвлөрсөн цэгт тавигдах шаардлага болон зохицуулах харилцааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагаас баталсан “Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”-аар зохицуулна.

7.6. Тээврийн хэрэгслийн энгийн хог хаягдал булшлах төвлөрсөн цэгт тавигдах шаардлага болон зохицуулах харилцааг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар”-аар зохицуулна.

7.7. Хоорондоо нийцгүй хог хаягдлыг нэг дор, нэг үүрэнд хамт булшлахыг хориглоно.

7.8. Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь булшилсан аюултай хог хаягдлын төрөл, нэг бүрийн байрлал, хэмжээ, гүнийг тэмдэглэсэн зураглал үйлдэж, аюултай хог хаягдлын бүтэц, байршлын талаар бүртгэл хөтөлнө.

7.9. Аюултай хог хаягдлын ландфилл нь хог хаягдал, түүнээс үүсэх шүүрлээс хөрс, газрын доорхи болон гадаргын ус бохирдохоос хамгаалах зориулалттай доторлогооны систем, шүүрэл цуглуулах, зайлуулах системтэй байна.

7.10. Аюултай хог хаягдлын ландфиллын доторлогооны систем, шүүрэл цуглуулах, зайлуулах систем нь стандартад заасан шаардлагыг хангасан байна.

7.11. Шүүрлийн системд ердийн түвшинээс их шүүрэл ялгарсан тохиолдолд авах хариу арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын удирдлага батална.

7.12. Газрын доорх усны хяналт-шинжилгээний цооног нь газрын гадаргаас доош босоо чиглэлд газрын доорх усны дээд үе хүртэл үргэлжлэх бөгөөд байгууламжийн газрын доорх усны хяналт-шинжилгээний систем нь газрын доорх усны хамгийн дээд үеэс дээж авах боломж бүхий гүнд суурилагдсан, тогтоосон цэгт гаргасан, хангалттай тооны хяналтын худагтай байна.

7.13. Газрын доорх усны хяналтын худгаас дээж авах бүртээ газрын доорх усны түвшинг хэмжиж, бүртгэл хөтөлнө.

7.14. Гүний худаг болон гадаргын усанд хяналт-шинжилгээ хийх талбай нь байгууламжийн хилээс 1500 метрийн радиус дотор байна.

7.15. Хоосон савыг ландфиллд булшлахад эзлэхүүний 90-ээс багагүй хувийг хогоор дүүргэж эсвэл жижиглэж, буталж эзлэхүүнийг нь багасгасны дараа булшилна.

7.16. Жижиг савлагаатай техник хэрэгслийн аюултай хог хаягдлыг (химийн бодис) зориулалтын саванд давхар савлаж, ландфиллд булшилж болох ба Хог хаягдлын тухай хуулийн 7.1.2-т заасан шаардлагыг хангасан байна.

7.17. Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь ландфиллыг бүрэн болон хэсэгчлэн хаахдаа батлагдсан зураг төслийн дагуу хучиж битүүмжлэх ба хучилтын давхарга нь стандартад заасан шаардлагыг хангасан байна.

7.18. Ландфиллын үйл ажиллагаа эрхлэгч нь ландфиллыг бүрэн хаасны дараа Хог хаягдлын тухай хуулийн 32.2-т заасан хяналт-шинжилгээ, арчилгаа үйлчилгээг авч хэрэгжүүлнэ.

7.19. Хаагдсан тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлын ландфиллын газар дээр аливаа үйл ажиллагаа эрхлэх, түүнийг ашиглахыг хориглоно.

7.20. Ландфиллын шаардлагатай газруудад дараах мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулсан байна.

7.20.1. аюултай хог хаягдал хариуцсан ажилтны овог нэр, утасны дугаар

7.20.2. гал унтраах хэрэгсэл, галын дохиолол, аюултай хог хаягдал асгарч алдагдсан үед ашиглах материалын байрлалыг заасан зураг, схем.

НАЙМ. ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ШАТААЖ УСТГАХАД ТАВИГДАХ ШААРДЛАГА

8.1. Аюултай хог хаягдлыг устгах, шатаах гэж Хог хаягдлын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасныг ойлгон ерөнхий шаардлагыг мөрдөж ажиллана.

8.2. Байгальд 10-аас дээш жилийн дараа уусах, байгальд хортой нөхцөл үүсгэх хог хаягдлыг булшлахаас бусад аргаар устгана.

8.3. Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологиор, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, зориулалтын байгууламж, тоног төхөөрөмжид зөвшөөрсөн газарт шатааж болно.

8.4. Төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг шатааж, эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр барьж болох ба хог хаягдлыг тээвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт хүргэх боломжгүй алслагдсан газар нутаг, суурин газарт өндөр даралт болон битүүмжлэл бүхий хог хаягдал шатаах зориулалтын, байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль орчны холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн жижиг оврын хог хаягдал шатаах байгууламж ашиглан дулаан, халуун ус үйлдвэрлэж хог хаягдлыг сэргээн ашиглаж болно.

8.5. Аюултай хог хаягдал шатаах үйл ажиллагаа эрхлэгч нь туршилтын шатаалт хийж, үйл ажиллагааны горим, технологийн үзүүлэлтийг тогтооно.

8.5.1. Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг шатаах явцад гарсан аюул ослын үед гарч болох эрсдэлд хариу үзүүлэх дараах бэлтгэлийн хангасан байх шаардлагатай;

8.5.2. Дохио өгөх дохиоллын болон дотоод холбооны систем суурилуулсан байх;

8.5.3. Зөөврийн галын хор, гал унтраах (хөөс, инертийн хий, хуурай химийн бодис гэх мэт гал унтраах зориулалтын тоноглол) болон асгарсан шингэний урсгалыг хязгаарлах тоноглол, хоргүйжүүлэх тоног төхөөрөмж, бодис, материалтай байх;

8.5.4. Даралттай ус хангалттай хэмжээгээр өгөх боломжтой хоолой, хөөс үүсгэгч тоног төхөөрөмж, ус бороожуулагч системтэй байх;

8.5.5. Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөнд аюул, осол үүсэх үед ажилтнуудын авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үүргийг тодорхойлж, дараах жагсаалтыг хавсаргасан байна:

8.5.6. Онцгой байдлын зохицуулагч болон ослын үед ажиллах шуурхай бүлэгт томилогдсон ажилтнуудын овог нэр, гэрийн хаяг, утасны дугаар.

8.6. Аюултай хог хаягдал шатаах зуух нь зуухны үйл ажиллагаа доголдох үед хог хаягдал ачаалах үйлдлийг зогсоох автомат системтэй байна.

8.7. Аюултай хог хаягдал шатаах зуух нь шаталт болон ялгаралд хяналт тавих төхөөрөмжтэй байх ба уг төхөөрөмж нь Хог хаягдлын тухай хуулийн 7.1.2-т заасан тухайн ААН-ын баталсан журмын шаардлагыг хангасан байна.

8.8. Шатаалтын зуух болон дагалдах тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд өдөрт нэгээс багагүй удаа хяналт тавина.

ЕС. ХҮЛЭЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА, ХЯНАЛТ

9.1. Аюултай хог хаягдал үүсгэгч нь Хог хаягдлын тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ:

9.1.1. Аюултай хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих;

9.1.2. Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан нь аюул осол гарсан, аюултай хог хаягдал асгарсан, алдагдсан тохиолдолд дараах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авна;

9.1.3. Галын дуудлага өгөх, гал тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, боломжтой бол унтраагуур, хэрэгсэл ашиглаж галыг унтраах.

9.2. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч газрын доорх ус, гадаргын ус, хөрс, агаарын хяналт-шинжилгээний болон хариу арга хэмжээний хөтөлбөртэй байх бөгөөд хөтөлбөрийн дагуу хяналт-шинжилгээг хийнэ.

9.3. Аюултай хог хаягдал үүсгэгч нь Хог хаягдлын тухай хуульд зааснаас гадна дараах үүргийг хүлээнэ.

9.3.1. Аюултай хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнд хяналт тавих;

9.3.2. Үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах, эргүүлэн ашиглах, хоргүйжүүлэх, устгах замаар байгаль орчинд ялгарах ялгарал, бохирдуулагчийн хэмжээг бууруулах;

9.3.3. Өөрийн үйл ажиллагаанаас үүссэн аюултай хог хаягдлаа устгах тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авах;

9.3.4. Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлаа устгах болон дахин боловсруулах боломжгүй тохиолдолд аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, устгах, дахин боловсруулах, экспортлох зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх;

9.3.5. Хэвийн үйл ажиллагааны үед аюултай хог хаягдалтай харьцах болон аюул ослын үед ажиллах зааварчилгааг түүнтэй харьцдаг ажилтан бүрээр боловсруулж, тэднийг сургаж, дадлагажуулах;

9.3.6. Анхны тусламж үзүүлэх зааварчилгаа боловсруулж, шаардлагатай материал, хэрэгслээр хангах.

9.4. Аюултай эд анги агуулсан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдан борлуулах үйл ажиллагаа эрхлэгчийг аюултай хог хаягдал үүсгэгч гэж үзэх бөгөөд дараах үүргийг хүлээнэ.

9.4.1. Үйлдвэрлэсэн, худалдан борлуулсан бараа, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн схемийг гаргаж, олон нийтэд нээлттэй байлгах, сурталчлах;

9.4.2. Үйлдвэрлэсэн, худалдан борлуулсан бараа, бүтээгдэхүүнээс үүсэх хог хаягдлыг цуглуулах;

9.4.5. Цуглуулсан хог хаягдлыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд ээлтэй аргаар хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортлох, эсхүл эрх бүхий аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлэх.

9.5. Аюултай хог хаягдал хариуцсан ажилтан нь аюул осол гарсан, аюултай хог хаягдал асгарсан, алдагдсан тохиолдолд дараах арга хэмжээг цаг алдалгүй шуурхай авна:

9.5.1. Галын дуудлага өгөх, гал тархахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, боломжтой бол унтраагуур, хэрэгсэл ашиглаж галыг унтраах;

9.5.2. Асгарсан аюултай хог хаягдлын асгаралтыг зогсоох, тархалтаас сэргийлэх арга хэмжээ авах, бохирдсон материал, хөрсийг цэвэрлэх;

9.5.3. Хүний эрүүл мэндэд аюул учруулахуйц галын аюул, дэлбэрэлт, асгаралт үүссэн, гадаргын усыг бохирдуулсан тохиолдолд тухайн орон нутгийн онцгой байдлын болон мэргэжлийн хяналтын байгууллагад яаралтай мэдэгдэж, дараах мэдээллийг өгнө:

9.5.3.1. аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, бүртгэлийн дугаар;

9.5.3.2. Аюул ослын төрөл (галын аюул, асгаралт гэх мэт), огноо, цаг хугацаа;

9.5.3.3. Аюулд өртсөн хог хаягдлын төрөл, тоо хэмжээ;

9.5.3.4. Үүссэн аюултай нөхцөл байдал болон үүсэж болзошгүй нөхцөл байдлын талаарх мэдээлэл;

9.5.3.5. Шаардагдах материал болон түүний хэмжээ.

9.6. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь ажилтнуудыг жилд нэг удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулна.

9.7. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулах хэмжээгээр агаар, хөрс, усанд санамсаргүй болон санаатайгаар аюултай хог хаягдал алдах, тэсэрч дэлбэрэх, галын аюул гарах үед үүсэх эрсдэлийг хамгийн бага хэмжээнд хүртэл бууруулах зорилго бүхий аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөтэй байна.

9.8. Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөнд шаардлагатай тохиолдолд байгууламжийн ажилтан болон ойр орчмын байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, оршин суугч иргэд, мал, гэрийн тэжээвэр амьтныг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг хавсаргасан байна.

9.9. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь дараах тохиолдолд аюул, ослын үед ажиллах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, орон нутгийн онцгой байдлын газраар батлуулна.

9.9.1. Үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдсөн;

9.9.2. Уг төлөвлөгөөг аюул, ослын үед ашиглан ажиллагаа явуулахад шаардлага хангаагүй;

9.9.3. Байгууламжийн загвар, барилга байгууламж, үйл ажиллагаа тээврийн хэрэгслийн хаягдлын цуглуулах, хадгалах, ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээс өөрчлөгдсөн;

9.9.4. Хүлээн авах тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлын зэрэглэл өөрчлөгдсөн;

9.9.5. Ашиглалтын болон бусад горимд өөрчлөлт орсон (гал, тэсрэх аюул үүсгэх, аюултай хог хаягдал алдагдах боломжтой хог хаягдлын хэмжээ ихэссэн);

9.9.6. Аюул, ослын үед авах арга хэмжээ өөрчлөгдсөн;

9.9.7. Аюул, ослын үед ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, материал өөрчлөгдсөн.

9.10. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч хяналт-шинжилгээгээр ялгарал, шүүрэл илэрсэн тохиолдолд авах арга хэмжээний төлөвлөгөөг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, нөлөөллийг арилгах арга хэмжээг авна.

9.11. Тээврийн хэрэгслийн хог хаягдал ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд дараах этгээдүүд хяналт тавина.

9.11.1. Иргэн;

9.11.2. Төрийн байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчид;

9.11.3. Хувийн хэвшлийн хуулийн этгээд, байгууллагын удирдлага, ажилтан, албан хаагчид;

9.11.4. Хэсгийн ахлагч, орон нутгийн идэвхтэн гишүүд;

9.11.5. Цагдаа, олон нийтийн хэв журам сахиулах байгууллага, иргэн, албан тушаалтан;

9.11.6. Олон улсын байгууллага;

9.11.7. Орон нутгийн төлөөлөгч, бүрэн эрхэт гишүүд;

9.11.8. Мэргэжлийн хяналтын байцаагч;

9.11.9. Хог хаягдлын асуудал хариуцсан нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан;

9.11.10. Байгаль хамгаалагчид.

9.12. Монгол улсын Хог хаягдлын тухай хуувь болон бусад холбогдох журамд тавигдах шаардлагыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэл эрүүгийн шинжтэй бол Эрүүгийн хуулийн, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Хог хаягдлын тухай хууль болон Зөрчлийн тухай хууль, бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

9.13. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тээврийн хэрэгслийн болон бусад хог хаягдлаа зориулалтын дагуу Эрх бүхий этгээдэд хүлээлгэн өгөх үүрэгтэй.

9.14. Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг ангилах төрөл, зүйлийг холбогдох хууль, тогтоомжийг үндэслэн орон нутгийн онцлогоос хамаарч тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож болно.

9.15. Тээврийн хэрэгслийн энгийн болон аюултай хог хаягдлыг цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь Хог хаягдлын тухай хуулийн 26.1-д зааснаас гадна дараах шаардлагын дагуу ажиллана:

9.15.1. Орон нутгийн мэргэжлийн хяналт, цагдаа болон онцгой байдлын байгууллагад өөрийн байгууламжийн бүтэц, үйл ажиллагаа, устгаж, боловсруулж байгаа хог хаягдлын шинж чанар, гарч болзошгүй аюул осол, ажилтнуудын ажлын байрны байршил, байгууламжийн доторх орц, гарц, зам, ослын гарцын талаар жил бүр танилцуулж, мэдээллээр хангана.

9.16. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн жилд гүйцэтгэсэн ажлын тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан маягтын дагуу гаргаж, холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

9.17. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд Хог хаягдлын тухай хууль болон холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

АРАВ. ТӨЛБӨР, ТОРГУУЛЬ

10.1. Тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 32.7-д заасан зардлыг итгэлцлийн сан байгуулж төвлөрүүлэх тохиолдолд дараах журмыг мөрдөнө:

10.1.1. Нийт зардлыг тухайн байгууламжийн ажиллах жилд хувааж, нэг жилд ноогдох хэмжээг тогтооно;

10.1.2. Эхний жилд ноогдох зардлыг анхны хог хаягдлаа хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор, дараагийн жилүүдэд өмнөх жилийн зардал дансанд төвлөрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тус тус итгэлцлийн санд төвлөрүүлнэ. Аюултай хог хаягдлыг хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч Хог хаягдлын тухай хуулийн 32.7-д заасан зардлыг барьцаа хөрөнгө байршуулах замаар төвлөрүүлэх тохиолдолд нийт зардлыг анхны хог хаягдлаа хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор барьцаа хөрөнгийн дансанд байгууламжийг хаах хүртэлх хугацаагаар, зарцуулах эрхгүйгээр байршуулна.

10.2. Автомашиныг дахин боловсруулагч бус мөртлөө өөрт ашигтайгаар автомашиныг худалдан авч цуглуулах эсхүл тухайн автомашиныг задлах, дахин боловсруулагчид зуучилсан тохиолдолд иргэнг 200000 /Хоёр зуун мянга/ төгрөг, хуулийн этгээдийг 1000000 /Нэг сая/ хүртлэх төгрөгөөр торгож Зам тээврийн хөгжлийн яамны санд төвлөрүүлнэ.

10.3. Автомашиныг задлах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгчийн авах шимтгэлд дараах төлбөрүүд хамаарна.

АРВАН НЭГ. ХОРИГЛОХ

11.1. Доорхи төрлийн хог хаягдлыг ландфиллд булшилж устгахыг хориглоно:

11.1.1. Шатамхай болон урвалын идэвхтэй хог хаягдал;

11.1.2. Хүн, малын эмнэлэг, эрүүл мэндийн төвийн эмчилгээ, сувилгаанаас үүссэн, эрүүл мэндийн байгууллагаас халдваргүйжүүлээгүй хог хаягдал;

11.1.3. Савлагаагүй шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал;

11.1.4. Судалгаа, шинжилгээ, сургалтын явцад үүссэн, хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд үзүүлэх нөлөөлөл нь тогтоогдоогүй шинэ, эсвэл шинж чанар нь судлагдаагүй химийн бодисын хаягдал;

11.2. Хог хаягдлын хуулийн 39.1-д заасны загуу тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлыг ашиглах, хадгалах, түр байршуулах, устгах зорилгоор Монгол Улсад импортоор оруулахыг хориглоно.

11.3. Хог хаягдлын тухай хуулийн 39.2-д заасны дагуу тээврийн хэрэгслийн аюултай хог хаягдлыг Монгол Улсын хил дамжуулан тээвэрлэхийг хориглоно.